

НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ШҮҮМЖ

Б. Мягмаржав

**НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙГ СУДЛАХ АСУУДАЛД
(Ази, Африкийн зарим орнуудын жишээн дээр)**

Дэлхийн таван тив тус бүрт байгалийн бэлчээрийг ашиглан мал аж ахуйг янз бүрийн хэмжээгээр хөгжүүлж байна. Үүнээс: нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуй зөвхөн Ази, Африк тивд үндсэндээ байршиж байгааг тохиолдол хэмээн үзэж болохгүй билээ. Тив тус бүрт газар зүйн байдлаас хамаарч нүүдлийн мал аж ахуйг эрхлэх арга нь өөр өөр боловч, тэжээлийн баазын үндэс нь байгалийн бэлчээр хэвээр байна. Энэ учраас дээрх асуудлыг олон талаас судлах нь зөвхөн шинжлэх ухааны хувьд төдийгүй, онол-практикийн чухал ач холбогдолтой асуудал болно.

Нүүдлийн мал аж ахуйг эрдэмтэд янз бүрээр үздэг. Зарим эрдэмтэд нүүдлийн мал аж ахуйг хоцрогдсон, үеэ өнгөрүүлсэн, бүдүүлэг аж ахуй¹ хэмээн үздэг.

Нөгөө нэг хэсэг эрдэмтэд нүүдлийн мал аж ахуй бол хүрээлэн буй орчныг хамгаалах нэгэн арга гэж үздэг. 1970 онд монголч эрдэмтдийн их хуралд тавьсан илтгэлдээ бид энэ санааг дэмжсэн билээ.

Д-р Ф. Фрезер Дорнод Африкийн мазойн нүүдэлчдийн мал аж ахуйг эрхлэх мэдлэг нь байгаль орчныг зохистой ашиглахад хангалттай бөгөөд хүмүүс одоогоор эзэмшээгүй дэвсгэр нутгийг ашиглах чухал хэлбэр гэж үзэж байлаа.

1970 оны эхэн үеийн байдлаар Африкт 1,5, Азид 5 сая орчим хүн ам нүүдэл, хагас нүүдлийн аргаар мал аж ахуйг голчлон эрхлэж² байсан ба дэлхийн хэмжээгээр нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуй бүхий 28 орон байна.³ Үүний дотор Афганистан, Иордан, Израйль, Ирак Иран, Йемен, БНМАУ, Энэтхэгийн зарим нутаг, Түрк зэрэг Азийн арван долоон орон багтаж байна. Африк тивд Алжир, Баруун Сахар, Дээд Вольта, Египит, Кени, Ливан, Мавритан, Мали, Марокко, Нигери, Судан, Сомали, Тунис, Чад, Этиоп зэрэг арван зургаан орон байна. Эдгээр орныг газар зүйн зарим хүчин зүйлтэй холбон үзвэл уур амьсгалын янз бүрийн бүсэнд зарим бага нутаг дэвсгэртэй улс бүхэлдээ уур амьсгалын нэгэн бүсэнд багтана.

Африк тивийн нүүдэл, хагас нүүдлийн бүх орон халуун ба дулаан уур амьсгалын бүсэнд хамаарагдаж байдгаас Дээд Вольта, Кенигээс бусад 14 орны нутаг дэвсгэрийн үлэмж хэсэг халуун бүсэнд, харин дулаан бүсэнд Алжир, Египет, Марокко, Тунисын умарт нутаг тус тус хамаарагдах аж.

Ази тивээс халуун бүсэнд Афганистан, Иран, Пакистан зэрэг 10, дулаан бүсэд Иордан, Иракийн үллэмжхэн хэсэг зэрэг 11 орны нутаг тус тус хамрагдаж байна. Турк улс зөвхөн дулаан, Йемен, БНАЙАУ, Оман,

1. Г. Беш. География мирового хозяйства. М. 1,669, с. 57-58.

2. Н. Дангаасүрэн «Гуравдахь ертөнц»:

(Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал), УБ, 1977, 48-р тал.

3. Жур. «Народы Азии и Африки», 1972, № 4. с. 21.

Саудын Арави зэрэг орнууд халуун; Израйль Иордан тус тус дулаан бүсэд хамаарагдана.

Ерөнхийдөө Африк тивийн нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуй халуун ба дулаан бүсэд, Ази тивийнх мөн халуун ба дулаан уур амьсгалын бүсэд багтах онцлог байдал харагдаж байна.

Дэлхийн хэмжээгээр нүүдлийн мал аж ахуйт орны уур амьсгалын дундачийг халуун бүс түүнээс өмнөт зүгт экватор, хойт зүгт дулаан бүс тус тус тодорхойлж байна. Уур амьсгалын дээрх байдал нь тухайн орны хөрс, ургамлын нөмрөг үүсэн хөгжихөд үзүүлэх нэгэн гол хүчин зүйл зүйл болно. Түүнээс гадна ургамлын нөмрөг нь уур амьсгалдаа эргэж нөлөөлөн бичил уур амьсгал бүхий орчныг бүрдүүлдэг билээ.

Дэлхийн ургамлын нөмрөгийг газар зүйн бүрхэвчтэй нь холбон хэд хэдэн бүсэнд хуваан үзнэ.

Үүнд:

1. Цармын бүсэд ойгүй, зөвхөн мөөг, замаг бүхий доод ургамал, хөвд, тод өнгө бүхий туйлын ургамал ургана. Харин цармын өмнөт хэсэгт бутлаг ургамал нилээд тохиолдоно. Энэ бүсэд зөвхөн цаа бугын аж ахуй үүсэн хөгжиж иржээ.

2. Сэрүүн орны ойн бүс нь бөмбөрцгийн хойт хэсгийн өргөн их зурвасыг хамран шилмүүст, навчит болон холимог ойгоор бүрхэгдэнэ. Энд үхэр адуу болон бог мал өсч үржинэ.

3. Ойт хээр болон хээрийн бүсэд армаг тармаг ойгоос гадна хээрийн бутлаг ургамал зонхилно. Тэнд үхэр, адуу, бог малд тохиромжтой.

4. Цөлийн бүс нь ургамлын бүрхэвч нэн сийрэг, ургамлын үндэс нь хөрсөнд гүн орж газрын дээрх эд эрхтэн болон навч цөөнтэй байх онцлог той. Тэнд бог мал, тэмээнд тохиромжтой.

5. Халуун орны ойт хээрийн бүс нь Африк, Ази, Өмнөт Америк, Австралид тохиолдох ба бүдүүн иш бүхий хээрийн ургамал, ганц нэгээр ургах мод бутлаг ургамалтай. Тэнд бог мал, үхэр өсгөн үржүүлдэг.

6. Халуун орны ойн бүсэд мөнх ногоон мод, дулаанд зохицсон бусад мод ургана. Жилийн дөрвөн улиралд үлэмж хэмжээний хур дундас жигд унана.

Нүүдэл болон хагас нүүдлийн мал аж ахуйтай орнууд ургамлын янз бүрийн бүсэд байршин буй.

Африк тивийн 13 орон цөлийн бүсэд, халуун орны ойт хээрийн бүсэд 11, дулаан бүсэд 4 орон тус тус хамрагдаж байна.

Ерөнхийдөө нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуй нь Африкийн цөл, халуун орны ойт хээрийн бүсэд байршиж байна.

Ази тивд байгаа бэлчээрийн мал аж ахуйт орнууд нь Африк тивийн орнуудыг бодвол ургамлын олон бүсэд хамаарагдах онцлог харагдаж байна. Үүнд уулархаг нутгийн ургамлын бүсэд 6, сэрүүн орны ойн бүсэд 1, ойт хээр ба хээр талд 3, цөлийн бүсэд 16, халуун орны ойт хээрийн бүсэд 6, дулаан бүсэд 5 орны нутаг дэвсгэр тус тус хамрагдаж байна.

БНАЙАУ, Оман зөвхөн цөлийн бүсэд хамрагдаж байхад бэлчээрийн мал аж ахуй бүхий ЗСБНХУ, БНМАУ болон БНХАУ ургамлын 3—4 бүсэнд хамрагдах онцлогтой байна. Тив тус бүрт уур амьсгал болон газар зүй, ургамлын ямар бүсэнд хамрагдаж байгааг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Өмнөт Америкт цөөн улс бэлчээрийн мал аж ахуйтай юм. Тэнд бэлчээрийн мал аж ахуй бүхий Аргентин, Уругвай, Парагвай, Бразили мэт орнууд ихэнхдээ халуун дулаан бүсэнд оршиж, ургамлын бүрхэвчээр цөл болон халуун орны ойт хээр, хээрийн бүс голлох байдалтай юм.

Дэлхийн хэжээгээр давхардсан тоогоор нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуй бүхий 28 орон халуун, 19 орон дулаан уур амьсгалд, ургамлын нөм-

ТИВ	Уур амсгалын бүсэд хамрагдах орнуудын тоо				Ургамлын нөмрөгийн бүсэд хамрагдах оруудын тоо					
	субэкватор	халуун	дулаан	сэрүүн	Сэрүүн орны ойно бүс	Ойт хээр ба хээр	цөл	Халуун орны ойт хээр	дулаан	Өндөр уулсын
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
Африкийн нүүдлийн мал аж ахуйтай орон	9	14	4	-	-		16	7	4	-
Азийн нүүдлийн болон бэлчээрийн мал аж ахуйтай зарим орон	1	10	11	3	1	5	16	6	5	6
Латин Америкийн бэлчээрийн мал аж ахуйтай орон	2	5	4	2	3	2	2	3	2	5
Дэлхийн хэмжээгээр	12	28	19	5	4	7	34	16	11	11

рөгийн хувьд 34 орон цөл, 19 орон дулаан орны ойт хээрийн бүсэд хамрагдаж байгаагаас үзэхэд нүүдлийн мал аж ахуйн газар зүйн нийтлэг шинж бол тачир ургамалтай, хуурайвтар нутгийг хамарсанд оршино

Газрын хөрс, уур амьсгал зэрэг байгалийн бусад бүрэлдэхүүн хэсгийн нөлөөн дор бий болсон ургамлын нөмрөгийн дээрх өвөрмөц бүсэд нүүдлийн мал аж ахуй үүсэн хөгжиж цаашдаа дэлхийн нийт мал аж ахуйд зохих байр сууриа хадгалах нь магадтай тул энэхүү асуудлыг олон талаас судлан үзэх явдал чухал ач холбогдолтой юм.

Газрын хотгор гүдгэр, ус, ургамал, уур амьсгал зэрэг олон зүйл харилцан бие биедээ үйлчилж газар зүйн бүсийг бүрдүүлж улмаар мал аж ахуй эрхлэх технологийг бий болгох нэг үндсэн хүчин зүйл болдог билээ.

Дээрх байдлаас үзвэл дэлхийн нүүдлийн мал аж ахуйн газар зүйн зонхилох бүс нь халуун болон дулаан бүс бөгөөд бөмбөрцгийн умарт хэсгийн 50-ын өргөргөөс урагш экватор хүртэлх нутгийг үндсэнд нь хамарч байна.

1975—1976 Оны байдлаар нэг хүнд ногдох бүх төрлийн биет болон томъёолсон нэгжид шилжүүлсэн малыг тодорхойлон үзэх нь өгүүлэгдэн бүхий хоёр тивд нүүдлийн мал аж ахуй хэрхэн байршсаныг харуулах юм. Тэгэхдээ тус судалгаанд БНХАУ, Энэтхэг улсын бүх нутаг биш, зөвхөн нүүдлийн мал аж ахуйтай хэсгийн бэлчээрийн талбай, малыг (БНХАУ-д Өвөр Монгол, Энэтхэг улсад Тарын цөл г.м.) хамруулан, Ази тивээс Арабын нэгдсэн эмират, Катар, Оман, Африкийн баруун Сахар, Ливи, Мавритан зэрэг хэд хэдэн орны материалыг оруулаагүйгээр дүнг гаргав.

Нүүдэл, хагас нүүдлийн мал аж ахуйтай Азийн орнууд нь Ази тивийн бүх нутгийн 30 гаруй, Африкийн орнууд Африк тивийн бүх нутгийн 40 гаруй хувийг тус тус эзэлж байна. 1975—1976 оны байдлаар дээрх орнуудад 368 сая хүн байснаас Азид 207,1 сая (БНХАУ, Энэтхэг орохгүй гээр), Африкт 160,9 сая нь тус тус оршиж байв.

Нэг хүнд ногдох малыг биет болон томъёолсон нэгжид шилжүүлэн тодорхойлоход малын толгойн тоо нь тоон утгыг төлөөлөх бол томъёолсон нэгжид (малыг ашиг шим, хөдөлмөр зарцуулалт, тэжээлээр тус тус томъёолсон нэгжид шилжүүлж болдог шилжүүлсэн тоо нь чанарын нэгэн гол үзүүлэлт болдог билээ.

Дээрх орнуудын малыг НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан үхэрт шилжүүлэх коэффициентийг (нэг үхэр 10 хонь, 2/3 адуутай

		Нэг хүнд ноогдох үхэрт шилжүүлсэн мал хоёр тивийн хэмжээгээр										Үүнээс							
		Нийт талбай (мян. Км ²)			Нийт хүн сая-аар			Мал сая-аар				Их (1 зэрэг)							
		Талбай (мян. Км ²)		Хүн (сая-аар)		Талбай (мян. Км ²)		Хүн (сая-аар)		Талбай (мян. Км ²)		Хүн (сая-аар)		Талбай (мян. Км ²)		Хүн (сая-аар)			
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%		
A		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
1. Ази		8816,7	100,0	207,1	100,0	90,4	100,0	1565,0	17,7	1,5	0,8	6,2	6,9						
2. Африк		14357,6	100,0	160,9	100,0	125,8	100,0	8314,3	57,9	60,2	37,4	99,4	79,0						
3. Хоёр тивийн дүн		23174,3	100,0	368,0	100,0	216,2	100,0	9879,3	46,2	61,7	16,8	105,6	48,9						
Хоёр тивийн дунджаас																			
		Ойролцоо (II зэрэг)						Бага (III зэрэг)											
		Талбай (Км ²)		Хүн (сая-аар)		Мал (сая-аар)		Талбай (Км ²)		Хүн (сая-аар)		Мал (сая-аар)		Талбай (Км ²)		Хүн (сая-аар)			
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%		
		13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24						
1. Ази		2674,4	30,4	140,3	67,7	67,7	74,9	4577,3	51,9	65,3	31,5	16,5	18,2						
2. Африк		2046,6	14,3	23,9	14,8	14,6	11,6	3996,7	27,8	76,8	47,8	11,8	9,4						
3. Хоёр тивийн дүн		4721,0	16,8	164,2	44,6	82,3	38,1	8574,0	37,0	142,1	38,6	28,3	13,0						

тэнцэнэ) хэрэглэн томёолсон нэгжид шилжүүлэв. (II хүснэгт). Хоёр тивийн хэмжээгээр нэг хүнд ногдох үхэрт шилжүүлсэн малын хэмжээг дээрх хоёр тивийн дундагчтай ойролцоо, түүнээс их болон бага байгаа орнууд гэж гурван зэрэгт хувааж болно. Үүнд:

1-р зэрэгт нь үхэрт шилжүүлсэн малын тоогоор хоёр тивийн дундажаас их бүлэгт бүх нутгийн 46,2%, хүн амын 16,8%, малын 48,9% тус тус хамрагдаж байна. Энд Ази тивээс зөвхөн БНМАУ, Африкаас Сомали, Этиопи зэрэг борон хамрагдаж байна.

2-р зэрэгт дэлхийн дундагчтай ойролцоо бүлэгт бүх нутгийн 16,8%-тай тэнцэх талбайтай, 44,6%-тай тэнцэх хүн ам бүхий орнуудад бүх малын 38,1% нь оршиж байна. Үүнд Ази тивээс Афганистан, Турк, Африкаас Кени, Нигер зэрэг торон хамрагдана.

3-р зэрэгт дэлхийн дундажаас бага бүлэгт хоёр тивийн нутгийн 37%, хүний 38,6%, малын 13% нь хамрагджээ. Тухайлбал Ази тивээс Иордан, Иемен, Сири зэрэг 7 орон, Африкаас Алжир, Тунис зэрэг 4, бүгд 10 гаруй орон орж буй.

Ерөнхийдөө дэлхийн нүүдлийн мал аж ахуйн хувьд бүсийн дундажаас их бүлэгт малын үлэмж хэсэг, харьцангуй цөөн хүн амтай орон, мөн дундажаас бага бүлэгт ихээхэн хүн ам, малын баганхи хэсэг хамрагдах онцлог байдал харагдаж байна. Монгол оронд хангай, хээр, говь, алтайн дөрвөн янз хагас нүүдлийн хэлбэр оршиж байна.

Монгол орны хангайн бүсэд бэлчээр ашиглахтай төстэй хэлбэр нь БНХАУ-ын Өвөр Монголын автономит районы нуга хээрийн бүс, Арабын хойгт Тигр мөрнөөс баруун хойших нутаг, Монгол ба Туркийн хээрийн бүсийн бэлчээр ашиглах хэлбэр нь БНХАУ-ын Өвөр Монголын автономит районы хээрийн бүс, өмнөт Америк, цөлийн нүүдлийн хэлбэр нь Ази, Африкийн нүүдлийн мал аж ахуй бүхий нилээд олон оронд, Алтайн нүүдлийн хэлбэр нь Афганистан, Монгол, ЗСБНХУ-ын дундад Азийн орнуудын уулархаг нутаг, БНХАУ-ын Төвдийн район, Газрын Дундад тэнгисийн хавийн Испани, Португали мэт уулархаг нутагт тус тус ямар нэг хэмжээгээр тохиолдож байна,

Нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийн зарим үзүүлэлтээр манай орон дэлхийн нүүдлийн мал аж ахуйт орны дотор тэргүүн орны нэг болдог нь манай улс дэлхийн хэмжээнд нүүдлийн мал аж ахуйг шинжлэн судлахад нэн чухал төлөөлөх хэв шинж бүхий орон болсоор ирсний уг учрыг илтгэн харуулж байна. Ингэхлээр нэг талаас урьдын цагт удтал бүрэн нүүдлийн байсан монгол орны мал аж ахуйн өнөөгийн шинжилгээ судлагааны ажлыг улам гүнзгийрүүлэн эрчимжүүлэх, нөгөө талаас энэ судлагааны үр дүнг Ази, Африкийн нүүдлийн мал аж ахуй бүхий бусад оронтой харьцуулан шинжлэх явдал, дээр дурдсанчлан зөвхөн шинжлэх ухааны төдийгүй онол-практикийн чухал ач холбогдолтой асуудал болно.

Дэлхийн нүүдлийн мал ажахуйг зөвхөн шинжлэх ухааны хувьд төдийгүй, практик ач холбогдлын талаас нь байгаль болон нийгмийн хуулиудтай холбон судлах явдал өнөө үеийн шийдвэрлэвэл зохих чухал асуудлын нэг болж байна.